



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/АЧ

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Айл өрх болон зарим аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөрийг төрөөс хариуцах болсонтой холбогдуулан Эрчим хүчний сайдын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 267 дугаар тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хангамж, хэрэглээг зохицуулах түр журам”, 269 дүгээр тушаалаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ыг хэрэгжүүлж байгаа цахилгаан, дулааны эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2020 оны 12 дугаар сар болон 2021 оны 01-06 дугаар сарын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын хөнгөлөлтөд хамрагдсан хэрэглэгчийн тоо, хэрэглээ, төлбөр тооцооны гүйцэтгэл, төлбөр нэхэмжилсэн тайлан, мөнгөн урсгалын гүйлгээнд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Бекболат

-Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Н.Амартөвшин

-Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч

Гишүүд:

Д.Мөнхжаргал

-Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч

С.Жанцанхорол

-Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн

Б.Энхтуул

-Эрчим хүчний яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн

170600121

Ч.Цоодол	-Эрчим хүчний зохицуулах хорооны Дотоод аудитын газрын дарга
Ц.Өлзийжаргал	-Эрчим хүчний зохицуулах хорооны Үнэ тариф, зах зээлийн газрын Зах зээлийн судалгаа, хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Бат-Эрдэнэ	-Эрчим хүчний зохицуулах хорооны Тусгай зөвшөөрөл, хяналтын газрын мэргэжилтэн
Ч.Жаргалмаа	-Хөндлөнгийн аудитор

2. “Цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уурын төлбөр тооцоог зохицуулах түр журам”-ын дагуу төрөөс хариуцаж байгаа айл өрх, зарим аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн эрчим хүчний төлбөр тооцооны гүйцэтгэл, мөнгөн урсгалыг тусгай зөвшөөрөл эзэмшигч тус бүрээр хянан шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийн удирдамж, ажлын төлөвлөгөө, хуваарь гарган газар дээр нь бодит гүйцэтгэлтэй тулган ажиллаж, хяналт шалгалтын дүн, цаашид авах арга хэмжээний саналыг тухай бүр танилцуулахыг Ажлын хэсэг /Х.Бекболат/-т үүрэг болгосугай.

3. Хяналт, шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг хариуцаж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах хороо /А.Тлейхан/-д даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Насантогтох/-д даалгасугай.

САЙД



Н.ТАВИНБЭХ